

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар
сарын ...-ний өдөр

№

Улаанбаатар хот

Барилга угсралтын ажил гүйцэтгүүлэх гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г Нэг талаас “.....” ХХК (улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, цаашид “Захиалагч”гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал, Нөгөө талаас: “.....” ХХК (улсын бүртгэлийн дугаар....., регистрийн дугаар, цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж захирал /цаашид хамтад нь талууд гэх/ нар нь Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль, БНБДболон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, харилцан тохиролцсоны үндсэн дээр байгуулав.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1.1. Энэхүү гэрээний гол зорилго нь гүйцэтгэгч гэрээнд заасан барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх, захиалагч нь гүйцэтгэгчид хэлэлцэн тохирсон ажлын хөлсийг төлөхөд оршино. Гүйцэтгэгч нь барилга барих тусгай зөвшөөрлийн БУ.....тоот гэрчилгээтэй болно.
- 1.2. Барилга угсралтын нийт талбайн нь..... м² байх ба ажлын зардал, хөлс нийт төлбөртөгрөг болно. Үнийн дүнд гэрээт ажлын цалин, машин механизм, тээврийн зардал, магадлашгүй ажлын зардал, нэмэгдэл зардал болон НӨАТ болон бусад татвар багтсан болно.
- 1.3. Гүйцэтгэлийн баталгааны 10 хувийг зөвшөөрөв.
- 1.4. Энэхүү гэрээгээр гүйцэтгэх гэрээт ажил гэдэгт: Улаанбаатар хот,дүүрэг,дүгээр хороо,айлын орон сууцны нийт барилга баригдана.
- 1.5. Үүнд: барилгын зоорь, цутгамал төмөр бетон каркас угсралтын ажил, дээврийн парпет /хашлага бетон/ гаражийн пандус, техникийн өрөөний төмөр бетон хийц, балкон террасны бетон хийц, хонгилын шат, түшиц хана, барилгын хийц бүтээц каркасын угсралттай холбоотой бүхий л гагнуурын ажил гэх мэт бетон цутгалтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгэхийг ойлгоно.

ХОЁР. ГЭРЭЭТ АЖИЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 2.1. Захиалагч, гүйцэтгэгч нар ажлын хэсэг гаргаж Барилгын ажил гүйцэтгэх талбайг акт үйлдэж хүлээлцэнэ.
- 2.2. Гүйцэтгэгч нь барилга угсралтын ажил гүйцэтгэх талбайн ойр орчим болон талбайн байршил, нэвтрэх зам, орц, гарц, бараа материал хадгалах, ачуулах, буулгах зай багтаамж, гэрээт ажлын гүйцэтгэлд нөлөөлж болохуйц бусад нөхцөл байдалтай бүрэн танилцсан, төлөвлөсөн, ажлын талбан зураглал хийсэн байх.
- 2.3. Гүйцэтгэгч нь 2.2-т дурдсан барилгын талбайн нөхцөл байдлыг сайн судлаагүйн улмаас үүссэн гэх үндэслэлээр барилга угсралтын ажлыг зогсоох, маргаантай асуудал гаргахгүй, мөн нэмэлт хөрөнгө шаардахгүй бөгөөд энэ нөхцөл байдлууд нь барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацааг сунгах үндэслэл болохгүй.
- 2.4. Гүйцэтгэгч нь долоо (7) хоног бүрийн ажлын эхний өдөр шаардлагатай ажлын хүч, техник тоног төхөөрөмж, барилгын материалын \арматур, зуурмаг г.м.\ талаарх мэдээллийг захиалагчид бичгээр гаргаж өгнө.
- 2.5. ... /*Үргэлжлэл бий* /